



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

### Гадаад сурталчилгааны ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, нийслэлийн Засаг даргын 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/400 дугаар захирамж, Газрын дүрмийн 4.1.11, 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэл Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах, жуулчдыг хэрэгцээт мэдээ мэдээллээр хангах, олон улсын үзэсгэлэн, арга хэмжээний үеэр тараах сурталчилгааны материал хэвлүүлэх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсугай.

2.Сурталчилгааны материал хэвлүүлэхэд шаардагдах 81,250,000 / наян нэгэн сая хоёр зуун тавин мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Уянга/-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналтад тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс /В.Батчимэг/-т даалгасугай.

ДАРГА *D. Balm* Д.БАТСҮХ



1150500135



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2023 оны 05 сарын 01 өдрийн  
А/20 дугаар тушаалын хавсралт

ГАДААД СУРТАЛЧИЛГААНЫ АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛАХАД  
ШААРДАГДАХ ТӨСВИЙН ЗАДАРГАА

2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

Д/д	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Улаанбаатар хотын сурталчилгааны сэтгүүл хэвлүүлэх (Англи хэлээр)	1500 ширхэг	5800	8 700 000
2	Улаанбаатар хотын сурталчилгааны сэтгүүл хэвлүүлэх (Япон хэлээр)	1500 ширхэг	5800	8 700 000
3	Улаанбаатар хотын сурталчилгааны сэтгүүл хэвлүүлэх (Солонгос хэлээр)	2000 ширхэг	5800	11 600 000
4	Улаанбаатар хотын сурталчилгааны сэтгүүл хэвлүүлэх (Герман хэлээр)	1000 ширхэг	5800	5 800 000
5	Улаанбаатар хотын сурталчилгааны сэтгүүл хэвлүүлэх (Орос хэлээр)	1000 ширхэг	5800	5 800 000
6	Улаанбаатар хотын сурталчилгааны сэтгүүл хэвлүүлэх (Хятад хэлээр)	2000 ширхэг	5800	11 600 000
7	Улаанбаатар хотын хөтөч ном хэвлүүлэх (Англи хэлээр)	1500 ширхэг	6500	9 750 000
8	Жуулчдад зориулсан Улаанбаатар хотын газрын зураг хэвлүүлэх	5000 ширхэг	1500	7 500 000
9	Visitulaanbaatar аппликейшн бүтээх	1	10 000 000	10 000 000
10	www.visitulaanbaatar.net сайтын сервэрийн төлбөр	1 жил	150 000	1 800 000
НИЙТ				81 250 000

--oo0oo--